



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/54

Амардалай

Спортын орон тооны бус зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг дэвсгэрийн нэгж Түүний Удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а" заалт, Аймгийн Засаг дарга, Сумын Засаг даргын 2021 онд байгуулсан Хамтран ажиллах гэрээний хавсралт 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус сумын Спортын орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүдэд: 9 жилийн биеийн тамирийн багш

9 жилийн сургуулийн эмч

ЭМТ-ийн дарга

Улсын бүртгэгч

1-р багийн засаг дарга

2-р багийн засаг дарга

3-р багийн засаг дарга

Хоёр. Тухайн жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын засаг даргын 2018 оны 04 сарын 02-ний өдрийн А/26 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ